



УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 12 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Загвар батлах тухай
/Албан хэрэгцээнд/

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Усны тухай хуулийн 16¹ дүгээр зүйлийн 16^{1.2}, 16^{1.3}, 16^{1.4.8}, 16^{1.4.9}, 16^{1.4.11} дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Стратегийн орд газарт цооног өрөмдөх зөвшөөрлийн загварыг 1 дүгээр, зааврыг 2 дугаар, Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийн загварыг 3 дугаар, зааврыг 4 дүгээр, Газрын доорх усны хяналт-шинжилгээний тайлангийн загварыг 5 дугаар, зааврыг 6 дугаар, Газрын доорх усны чанар, хяналт-шинжилгээний тайлангийн загварыг 7 дугаар, зааврыг 8 дугаар, Ус ашиглуулах дүгнэлт гаргах загварыг 9 дүгээр, зааврыг 10 дугаар, Хаягдал усны дүгнэлт гаргах загварыг 11 дүгээр, зааврыг 12 дугаар, Цооног хүлээлцэх актын загварыг 13 дугаар, зааврыг 14 дүгээр, Худаг /цооног/ гаргах зөвшөөрөл олгох загварыг 15 дугаар, зааврыг 16 дугаар, Цооног битүүмжлэх акт үйлдэх загварыг 17 дугаар, зааврыг 18 дугаар, Ус ашиглах гэрээ дүгнэх актын загварыг 19 дүгээр, Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ дүгнэх актын загварыг 20 дугаар, Усны бохирдлын эх үүсвэрийн мэдээллийг нэгтгэх загварыг 21 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Удирдлага, санхүүгийн хэлтэс, Усны нөөцийн хэлтэс, Ус ашиглалтын хэлтэс, Усны хяналт, шинжилгээний хэлтэс, Сав газрын захиргаадын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.МЯГМАР

161220201

Усны газрын даргын
2022 оны 05 дугаар сарын 2 өдрийн
4/28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

**СТРАТЕГИЙН ОРД ГАЗАРТ ЦООНОГ ӨРӨМДӨХ
ЗӨВШӨӨРЛИЙН ЗАГВАР**

.... оны ... дугаар ... сарын ...өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Ерөнхий мэдээлэл:

1. Орд газрын нэр:
2. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаар:
3. Худаг /цооног/ гаргах усны мэргэжлийн байгууллага:
4. Худаг /цооног/ гаргах байршил:
Хаяг:
5. Өрөмдлөгийн машин механизм, өрөмдлөгийн арга, техник хэрэгсэл:
6. Худаг /цооног/-ийн гүн: м; худаг/цооног/-ийн тоо:
7. Зориулалт: уул уурхайн технологийн усны эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны хайгуул судалгааны цооногууд, хүн ам, баяжуулах үйлдвэрлэл, усалгаатай газар тариаланд гэх мэт.

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН:

/ТАМГА/

ДАРГА

..... /Гарын үсгийн тайлал/
/Гарын үсэг/

**СТРАТЕГИЙН ОРД ГАЗАРТ ЦООНОГ ӨРӨМДӨХ
ЗӨВШӨӨРЛИЙН ЗАГВАРЫГ ХӨТЛӨХ ЗАЛВАР**

1. Стратегийн орд газрын нэрийг тодорхой бичсэн байна.
2. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаарыг тодорхойлж бичнэ.
3. Худаг /цооног/ гаргах усны мэргэжлийн байгууллагын нэр, регистрийн дугаар, тусгай зөвшөөрлийн дугаарыг бичнэ.
4. Худаг /цооног/ гаргах байршил /солбицол/-ыг бичих ба хаяг хэсэгт худаг, цооногийн байрлал нь аль хот, аймгийн сум дүүргийн нутаг, хороонд байрлахыг бичнэ.
5. Өрөмдлөгийн машин механизм, өрөмдлөгийн арга, техник хэрэгслийг бичихдээ өрөмдлөгийн машины марк, дагалдах техник тоног төхөөрөмж болох компрессор, насосны маркуудыг бичнэ.
6. Худаг /цооног/-ийн гүнийг бичихдээ геофизикийн хэмжилт судалгааг үндэслэн бичиж, тэмдэглэл хийнэ. Ажлын даалгавар болон геофизикийн хэмжилтийг үндэслэн худаг/цооног/-ийн тоог бичнэ.
7. Зориулалтын хувьд хүн ам, хөдөө аж ахуй, үйлдвэр, уурхай, эрчим хүч бусад гэснийг доогуур нь зурж тэмдэглэгээ хийх ба энд дурьдагдаагүй зориулалтыг нэмж бичнэ.

Тайлбар: Тавигдах шаардлага

а/ Усны эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны хайгуул судалгааны ажлын даалгаврыг батлуулсан байна.

б/ Геофизикийн хэмжилт хийлгэсэн дүгнэлтийг хавсаргасан байна.

в/ Худаг /цооног/ өрөмдөж байгаа газарт гадаргын болон газрын доорх усыг бохирдохоос хамгаалах арга хэмжээ авсан байна.

г/ Зөвшөөрөл өгсөн газраас өөр цэгт худаг, цооногийг шилжүүлж, өрөмдөхийг хориглоно.

д/ Ус ашиглагч худаг /цооног/ өрөмдүүлсний дараа Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулна.

е/ Ус ашиглагч худаг /цооног/-ийг усны мэргэжлийн байгууллагаас хүлээн авахдаа паспорт үйлдэн, холбогдох газар /Сав газрын захиргаа/-аар баталгаажуулалт хийлгэсэн байна.

Хавсаргах материалууд:

-Уул уурхайн эсвэл баяжуулах үйлдвэрийн технологийн усны эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны хайгуул судалгааны ажлын батлагдсан даалгавар, мониторингийн цооногийг өрөмдөх хүсэлтийг хавсаргасан байна.

-Худаг гаргахад геофизикийн хэмжилт хийлгэсэн дүгнэлтийг хавсаргах ба дүгнэлт нь мэргэжлийн байгууллагаар эсвэл мэргэжлийн зөвлөх инженерээр баталгаажуулсан байна.



Усны газрын даргын
2022 оны 02 дугаар сарын 12 өдрийн
А/28 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

УС АШИГЛАХ БОЛОМЖИТ НӨӨЦИЙН ДҮГНЭЛТИЙН ЗАГВАР

20.. оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар-...

Улаанбаатар хот

1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:
.....

2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага:
.....

3. Төслийн нэр, байршил:
.....

4. Тусгай зөвшөөрлийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт:
.....

5. Төслийн хүчин чадал, ажиллах горим:
.....

6. Ашиглах нөөцийн хэмжээ, усны эх үүсвэр:
.....

7. Төслийн үйл ажиллагаанд зарцуулах усны хэмжээ:
.....

8. Усны нөөц, ус хэрэглээний тооцоо:
.....

9. Цаашид авах арга хэмжээ, тавигдах шаардлага, зөвлөмж:
.....

Хянасан:
/Албан тушаал/ /Овог, нэр/

Боловсруулсан:
/Албан тушаал/ /Овог, нэр/

4/28



ДҮГНЭЛТИЙГ ГАРГАХАД АШИГЛАХ ЗААВАР

Дүгнэлтийн дугаарыг дүгнэлт гарсан дарааллын дагуу давхардуулахгүйгээр өгнө.

1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж, байгууллагын нэр, улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар, цахим хаягийг бичнэ.
2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан (нэмэлт тодотгол) боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллагын нэр, холбоо барих утасны дугаар, цахим хаягийг бичнэ.
3. Төслийн нэр, байршил хэсэгт тухайн төслийн нэр, байршил, харьяалагдах сав газрын нэрийг бичнэ.
4. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийн дугаар, тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны төрлийг бичнэ.
5. Төслийн хүчин чадал, ажиллах горим гэдэгт төслийн хэрэгжих нийт хугацаа, хүчин чадал, жилд ажиллах хоног, ажиллах горим, ажиллах хүний тоог бичнэ.
6. Ус хангамжийн эх үүсвэрийн төрлөөс хамаарч худгийн ундарга (л/сек), газарзүйн байршлын солбицол, усан сангийн эзлэхүүн (m^3), шүүрлийн усны ундарга (л/сек), голын нэр, өнгөргөлт ($m^3/сек$)-ээр нэгжээр тодорхой бичнэ.
7. Төслийн хоногт болон жилд ашиглах усны хэмжээг ашиглалтын зориулалт тус бүрээр буюу технологийн ус хэрэглээ (эргэлтээр болон нөхөн сэлбэлтээр) унд ахуй, зам талбайн тоосжилт дарах, ногоон байгууламж, нөхөн сэргээлт, техникийн усны хэрэглээг батлагдсан нормын дагуу тооцно.
8. Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах усны хэрэгцээг, тухайн усны эх үүсвэрээс хангахад хүрэлцээтэй эсэхийг тооцож дүгнэнэ.
9. Усны тухай болон холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн ус ашиглагчдад тавигдах шаардлага, усны нөөц ашигласны болон хаягдал усны дүгнэлт гаргуулах заалтууд болон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан усны нөөцийг бохирдол хомсдолоос хамгаалах тухай зөвлөмжийг тусгаж өгнө.